



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/148

Мөрөн сум

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг  
хязгаарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 15 дугаар зүйлийн 15.5.1, 15.2.1, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний олон улсын худалдаа, дотоод худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин тархах эрсдэл бүхий тайван бус зүүн, төв болон баруун бүсийн аймгуудаас ирэх мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарласугай.

2. Мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаас чиглэсэн мал, амьтныг нэвтрүүлэхдээ эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон шимэгчтэх өвчнийг эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан мал, амьтныг халдварт, өвчний шинжилгээний хуудастай тохиолдолд нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газрын дарга (Л.Ариунаа), сумдын Засаг дарга, Мал эмнэлгийн улсын байцаагч нарт зөвшөөрсүгэй.

3. Малчид иргэд, хуулийн этгээдэд энэхүү шийдвэрийг мэдээлэх, орон нутгийн түвшинд хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч дарга (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН